

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар

№	Д/д	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Суурь түвшин (2023 он)	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хариуцах нэгж	Хувь
“ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ” ЖИЛ Зорилго : АГААРЫН ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛНЭ.									
		ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ (САЯ.ХҮН), НИСЛЭГИЙН ТОО ХЭМЖЭЭ (ТОО) АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ (МЯНГАН.ТОНН),		IV улирал	1.73 САЯ ЗОРЧИГЧ 8.6 МЯНГАН.ТОНН АЧАА 63.454 НИСЛЭГ	2.2 САЯ ЗОРЧИГЧ 12.0 МЯНГАН.ТОНН АЧАА 71.124 НИСЛЭГ	2,012,861 зорчигч тээвэрлэснээс олон улсад 1,625,255 зорчигч, орон нутагт 387,606 зорчигч, 9,205 тонн ачаа, 200 тонн шуудан тээвэрлэсэн. Олон улсын 61,821 өнгөрөлтийн нислэг үйлдэгдсэн.	ГХАХ	
		Зорилт 1: АГААРЫН ТЭЭВРИЙГ ЛИБЕРАЛЧИЛНА.	Хэлэлцээрийн тоо, Нислэгийн багтаамж, давтамж нэмэгдүүлэх улс	I-IV улирал	Монгол Улс 43 улстай агаарын харилцааны хэлэлцээртэй. Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс, Узбекистан, Кувейт Улстай агаарын харилцааны хэлэлцээрийн төслийг эцэслэсэн.	Жилийн эцсийн байдлаар: Байгуулсан хэлэлцээрийн тоо 7; - Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс - Бүгд Найрамдах Латви Улс - Унгар Улс - Кувейт Улс - Бүгд Найрамдах Узбекистан улс - Бүгд Найрамдах Азербайжан Улс - Испанийн Вант Улс Үзэглэсэн хэлэлцээрийн тоо 3; - Австрали Улс - Иран Улс - Индонези Улс Нэмэгдүүлсэн цэг, давтамжийн тоо гүйцэтгэлээр		ГХАХ	
1.	1.1	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улстай Агаарын харилцааны	Хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг хангасан эсэх	I-II улирал	2023 онд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж,	Хагас жилийн байдлаар: I улиралд: Хэлэлцээр байгуулах бэлтгэл хангасан байна.	Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр	ГХАХ	100

		тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах.	Хэлэлцээр байгуулсан эсэх		агаарын харилцааны хэлэлцээрийн төслийг үзэглэсэн.	II улиралд: Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулсан байна.	байгуулсан. Энэхүү хэлэлцээрийг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 119 дүгээр тогтоолоор тус хэлэлцээрийг баталсан.		
2.	1.2	Бүгд Найрамдах Латви Улстай Агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах.	Хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг хангасан эсэх Хэлэлцээр байгуулсан эсэх	II-III улирал	2023 онд агаарын харилцааны тухай хэлэлцээрийн төслийг эцэслэн тохирч үзэглэсэн.	Хагас жилийн байдлаар: II улиралд: Хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг хангана. III улиралд: Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны гадаад албан томилолтын төлөвлөгөөтэй уялдуулан хэлэлцээрийг байгуулсан байна.	Бүгд Найрамдах Латви Улс нь Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулах дотоодын журмаа гүйцээсэн тухай 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр манай талд мэдэгдсэн. Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Латви Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Бүгд Найрамдах Латви Улсын Гадаад харилцааны дэд сайд бөгөөд Улс төрийн бодлогын захирал Андээжс Вилумсонс нар 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр гарын үсэг зурж, эцэслэн байгуулсан.	ГХАХ	100
3.	1.3	Унгар Улстай Агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах.	Хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг хангасан эсэх Хэлэлцээр байгуулсан эсэх	I-III улирал	2022 онд агаарын харилцааны тухай хэлэлцээрийн төслийг эцэслэн үзэглэсэн.	Хагас жилийн байдлаар: I улиралд: Хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг хангана. III улиралд: Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны гадаад албан томилолтын төлөвлөгөөтэй уялдуулан хэлэлцээрийг байгуулсан байна.	Монгол Улсын Засгийн газар, Унгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр эцэслэн байгуулсан. 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Монгол Улсын Засгийн газрын 185 дугаар тогтоолоор тус хэлэлцээрийг баталсан.	ГХАХ	100
4.	1.4	Кувейт Улстай Агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах.	Хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг хангасан эсэх	I-II улирал	2023 онд агаарын харилцааны тухай хэлэлцээрийн төслийг үзэглэсэн.	Хагас жилийн байдлаар: I улиралд: Хэлэлцээр байгуулах бэлтгэл хангана. II улиралд:	Монгол Улсын Засгийн газар, Кувейт Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны тухай хэлэлцээрийг хоёр талын 2024 онд зохион байгуулагдах өндөр дээд хэмжээний уулзалтын үеэр эцэслэн байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Кувейтийн тал	ГХАХ	90

			Хэлэлцээр байгуулсан эсэх			Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулсан байна.	дотоодын журмаа гүйцээсэн тухайгаа 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр манай талд мэдэгдсэн бөгөөд талуудын өндөр дээд хэмжээний уулзалт зохион байгуулах боломжийн талаар хэлэлцэж байна.		
5.	1.5	Бүгд Найрамдах Узбекистан Улстай Агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах.	Хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг хангасан эсэх Хэлэлцээр байгуулсан эсэх	I-II улирал	Хэлэлцээрийн төсөл солилцсон.	Хагас жилийн байдлаар: I улиралд: Хэлэлцээр байгуулах бэлтгэл хангана. II улиралд: Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулсан байна.	Агаарын харилцааны тухай хэлэлцээрийн төслийг талууд эцэслэн тохирч, дипломат шугамаар үзэглэсэн. Хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжиж, Ерөнхий сайдын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн захирамжаар хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод олгосон. Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 06 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд Узбекистан Улсад төрийн айлчлал хийх үеэр хэлэлцээрт гарын үсэг зурж, эцэслэн байгуулсан.	ГХАХ	100
6.	1.6	Азербайжан Улстай Агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах.	Хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг хангасан эсэх Хэлэлцээр байгуулсан эсэх	I-IV улирал	2016 онд агаарын харилцааны тухай хэлэлцээрийн төслийг үзэглэсэн.	Хагас жилийн байдлаар: I улиралд: Хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг хангана. II улиралд: Хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг хангана. Жилийн эцсийн байдлаар: III- IV улиралд: Агаарын харилцааны тухай хэлэлцээрийг байгуулсан байна.	Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Азербайжан Улсын Засгийн газар хооронд байгуулах хэлэлцээрийг хоёр талын холбогдох төлөөллүүд өндөр дээд хэмжээний айлчлал хийх үеэр хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг бүрэн хангасан.	ГХАХ	90
7.	1.7	Испанийн Вант Улстай Агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах.	Хэлэлцээрийг үзэглэсэн эсэх Хэлэлцээр байгуулсан эсэх	I-IV улирал	2021 онд хэлэлцээрийг үзэглэсэн.	Хагас жилийн байдлаар: I улиралд: Хэлэлцээрийг үзэглэх бэлтгэлийг ажлыг хангасан байна. II улиралд:	Монгол Улсын Засгийн газар, Испанийн Вант Улсын Засгийн газар хооронд байгуулах Агаарын харилцааны тухай хэлэлцээрийн төслийг 2024 оны 01 дүгээр сард Испанийн талд хүргүүлж, 2024 оны 10 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд Малайз Улсын Куала Лумпур хотод зохион байгуулагдсан Агаарын	ГХАХ	100

						Хэлэлцээр үзэглэсэн байна. Жилийн эцсийн байдлаар: III улиралд: Хэлэлцээр байгуулах бэлтгэл хангасан байна. IV улиралд: Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулсан байна.	харилцааны хэлэлцээрийн хурал ICAN 2024-ын үеэр уулзалт зохион байгуулж, Агаарын харилцааны хэлэлцээрийг үзэглэж, тохиролцлын бичигт гарын үсэг зурснаар 2018 онд байгуулсан агаарын харилцааны хэлэлцээрийн төслийг шинэчилж, хоёр улсын хооронд шууд нислэг үйлдэх эрх нээгдсэн.		
8.	1.8	Австрали Улстай Агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл үзэглэх.	Хэлэлцээрийг үзэглэсэн эсэх	I-IV улирал	Австралийн талаас хэлэлцээрийн төсөл ирүүлж, агаарын тээвэрлэгчдээс санал авч байна.	Хагас жилийн байдлаар: I улиралд: Австралийн талаас ирүүлсэн хэлэлцээрийн төсөлд агаарын тээвэрлэгчдээс санал авсан байна. II улиралд: Хэлэлцээрийн төслийг эцэслэн тохирсон байна. Жилийн эцсийн байдлаар: III-IV улиралд: Хэлэлцээрийн төслийг үзэглэсэн байна.	Малайз Улсын Куала Лумпур хотод 2024 оны 10 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Агаарын харилцааны хэлэлцээрийн хурал ICAN 2024-ын үеэр 23-ны өдөр уулзалт зохион байгуулж, Монгол Улс Австрали Улстай агаарын харилцааны хэлэлцээрийн төслийг үзэглэж, харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан.	ГХАХ	100
9.	1.9	Исламын Бүгд Найрамдах Иран Улстай Агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл үзэглэх.	Хэлэлцээр үзэглэх бэлтгэл ажлыг хангасан эсэх Хэлэлцээрийг үзэглэсэн эсэх	I-III улирал	Ираны талаас хэлэлцээрийн төсөл ирүүлж, агаарын тээвэрлэгчдээс санал авч байна.	Хагас жилийн байдлаар: I улиралд: Ираны талаас ирүүлсэн хэлэлцээрийн төсөлд агаарын тээвэрлэгчдээс санал авсан байна. II улиралд: Хэлэлцээрийн төслийг эцэслэн тохирсон байна. Жилийн эцсийн байдлаар: III улиралд:	Исламын Бүгд Найрамдах Иран Улсаас хэлэлцээрийн төсөлд тусгасан саналыг судлан үзэж, Монголын талаас энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж, 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Ираны талд хүргүүлсэн. Ираны талаас 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр дипломат шугамаар 2024 оны 04 дүгээр сарын сүүлээр биечлэн уулзалт хийх хүсэлтээ илэрхийлсэн. Ираны талыг Монгол Улсад урьж, уулзалтыг 2024 оны 04 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд, эсхүл 29-30-ны өдрүүдэд зохион байгуулах саналыг	ГХАХ	70

						Хэлэлцээрийн төслийг үзэглэсэн байна.	Ираны талд уламжилж өгөхийг хүссэн 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/635 дугаар албан бичгийг Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. 2024 оны 07 дугаар сард Ираны талаас цахим уулзалт хийх хүсэлтийн дагуу 07 дугаар сарын 29-ний өдөр цахим уулзалт зохион байгуулан Агаарын харилцааны хэлэлцээрийн төслийг хамтран хэлэлцэж ойрын хугацаанд эцэслэхээр тохиролцсон. Цахим уулзалтын дараа Агаарын харилцааны хэлэлцээрийг эцэслэн илгээсэн. Малайз Улсад 10 дугаар сарын 21-24-ний өдрүүдэд зохион байгуулагдаж буй Агаарын харилцааны хэлэлцээрийн ICAN 2024 хурлын үеэр уулзалт хийхээр тохирсон боловч Иран Улсаас тус хуралд оролцоогүй.		
10.	1.10	Бүгд Найрамдах Индонези Улстай Агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл үзэглэх.	Хэлэлцээр үзэглэх бэлтгэл ажлыг хангасан эсэх Хэлэлцээрийг үзэглэсэн эсэх	I-III улирал	Индонезийн талд хүргүүлэх хэлэлцээрийн төсөл бэлтгэж байна.	Хагас жилийн байдлаар: I улиралд: Хэлэлцээрийн төсөлд агаарын тээвэрлэгчдээс санал авсан байна. II улиралд: Хэлэлцээрийн төслийг эцэслэн тохирсон байна. Жилийн эцсийн байдлаар: III улиралд: Хэлэлцээрийн төслийг үзэглэсэн байна.	Бүгд Найрамдах Индонези Улсад хүргүүлэх хэлэлцээрийн төслийг бэлэн болгож, Индонези Улсын иргэний нисэхийн удирдах байгууллага руу 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр хэлэлцээр үзэглэх хүсэлтээ цахимаар хүргүүлсэн. Индонезийн талаас хариу хүлээж байгаа бөгөөд хэлэлцээрийн төслийг ИНЕГ-ын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 01/111 дугаартай албан бичгээр дахин Индонезийн талд хүргүүлсэн байна. Индонезийн тал хэлэлцээрийн төслийг хүлээн авснаа цахимаар мэдэгдэж, хэлэлцээрийн төслийг судлаад эргээд хариу өгөхөө мэдэгдсэн. Мөн Индонезийн Иргэний нисэхийн байгууллага нь бүрэн бүрэлдэхүүнээрээ солигдож байгаатай холбогдуулан хэлэлцээрийн төслийн ажил удаашраалтай байгаа талаар цахимаар хариу мэдэгдсэн.	ГХАХ	70
11.	1.11	Бүгд Найрамдах Солонгос Улстай Агаарын	Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт	I улирал	2023 оны 01 дүгээр сард уулзалт хийж,	Хагас жилийн байдлаар: I улиралд:	Монгол Улс болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Агаарын тээврийн удирдах байгууллагуудын төлөөлөгчид	ГХАХ	100

		харилцааны хэлэлцээ хийх, хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, нислэгийн тоо, чиглэлийг нэмэгдүүлэх.	оруулсан эсэх, нислэгийн багтаамж, давтамжийн тоог нэмэгдүүлсэн эсэх		Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.	Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж, нислэгийн багтаамж, давтамжийг нэмэгдүүлсэн байна.	хоёр улс хоорондын Агаарын харилцааны тухай уулзалт хэлэлцээг БНСУ-ын Сөүл хотноо 2024 оны 02 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уулзалт хэлэлцээний үр дүнд Монголын талаас томилогдсон агаарын тээвэрлэгчид Улаанбаатар-Бусан чиглэлд дурын агаарын хөлгөөр долоо хоногийн 9 удаагийн давтамжтай нислэг үйлдэх, мөн Инчеон, Гимпо, Бусан зэрэг хотуудаас бусад БНСУ-ын газар нутаг дээрх орон нутгийн 5 чиглэлд суудлын хязгаарлалтгүй, долоо хоногийн нийт 15 удаагийн давтамжтай нислэг үйлдэх боломжтой болсон.		
12.	1.12	БНХАУ-тай Агаарын харилцааны хэлэлцээ хийх, хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах.	Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулсан эсэх	I-II улирал	Хэлэлцээрийн төслийг боловсруулж байна.	Хагас жилийн байдлаар: I улиралд: Хэлэлцээ хийх хугацааг тохирсон байна. II улиралд: Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулан, нислэгийн давтамжийг нэмэгдүүлсэн байна.	БНХАУ-ын талтай хэлэлцээ хийх хугацааг тохирохоор харилцан санал солилцож байна. Иргэний нисэхийн ерөнхий газраас Иргэний нисэхийн салбарын хамтын ажиллагааны тулгамдсан болон Хятадын талаас агаарын харилцааны чиглэлээр удаашралтай байгаа асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсад суугаа БНХАУ-ын Бүрэн эрхт Элчин сайдтай 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр хийсэн уулзалтын тэмдэглэлийг 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 01/490 дугаартай албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. Монгол Улс, БНХАУ хооронд байгуулсан Агаарын харилцааны тухай хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж, томилогдсон агаарын тээвэрлэгчид гуравдагч улс руу аяллын дугаар хамтран ашиглах зохицуулалтыг тохирох саналаа 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/46 дугаар гадаад албан бичгээр БНХАУ-ын	ГХАХ	70

							Иргэний нисэхийн удирдах газарт хүргүүлсэн. Томилогдсон агаарын тээвэрлэгчид гуравдагч улс руу аяллын дугаар хамтран ашиглах зохицуулалтыг тохирох тухай Харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг боловсруулж, 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр БНХАУ-ын талд цахимаар хүргүүлсэн. БНХАУ-ын иргэний нисэхийн удирдах байгууллага манай төслийг хүлээн авснаа 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр мэдэгдсэн. Мөн 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр мэдэгдсэн дээрх бичгийн талаар хариу ирүүлэхийг хүссэн утга бүхий захиа цахимаар 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүргүүлээд байна.		
13.	1.13	Бүгд Найрамдах Филиппин Улстай Агаарын харилцааны хэлэлцээ хийх, хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, нислэгийн тоо, чиглэлийг нэмэгдүүлэх.	Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулсан эсэх, нислэгийн багтаамж, давтамжийн тоог нэмэгдүүлсэн эсэх	II-III улирал	Хэлэлцээрийн төслийг боловсруулж байна.	Жилийн эцсийн байдлаар: II улиралд: Хэлэлцээ хийх хугацааг тохирсон байна. III улиралд: Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж, нислэгийн багтаамж, давтамжийг нэмэгдүүлсэн байна.	Бүгд Найрамдах Филиппин Улсын иргэний нисэхийн удирдах байгууллагатай 2024 оны 10 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “DGCA 2024” хурлын үеэр уулзалт хэлэлцээ хийж, Агаарын харилцааны хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийн Санамж бичгийн төслийг Филиппиний талд өгсөн бөгөөд айлын талаас судлан хариу ирүүлнэ.	ГХАХ	90
14.	1.14	Тайландын Хаант Улстай Агаарын харилцааны хэлэлцээ хийх, хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, нислэгийн тоо, чиглэлийг нэмэгдүүлэх.	Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулсан эсэх, нислэгийн багтаамж, давтамжийн тоог нэмэгдүүлсэн эсэх	II-III улирал	Хэлэлцээрийн төслийг боловсруулж байна.	Жилийн эцсийн байдлаар: II улиралд: Хэлэлцээ хийх хугацааг тохирсон байна. III улиралд: Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж, нислэгийн багтаамж, давтамжийг нэмэгдүүлсэн байна.	Тайландын Вант Улсын Иргэний нисэхийн удирдах газартай хоёр талын агаарын харилцааны уулзалт, хэлэлцээрийг Нигер Улсад зохион байгуулагдсан ICAN 2022 уулзалтын үеэр 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хэлэлцээ хийж нислэгийн давтамж долоо хоногт 14 суудлын багтаамж харгалзахгүй байхаар, хоёрдогч гуравдагч талын оролцоотой аяллын дугаар хамтран ашиглах зохицуулалт тохирч Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.	ГХАХ	-

							Тус хэлэлцээрийн давтамжийг 43% тай буюу долоо хоногт 2 чиглэлд 6 удаагийн давтамжтай зорчигч тээврийн хуваарьт нислэг гүйцэтгэж байна. /Одоогийн Хэлэлцээрийн давтамжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй байгаа тул ЗТЯ-ны төлөвлөгөөнөөс хасагдсан./			
Зорилт 2: ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО.			Батлагдсан баримт бичгийн тоо	I-IV улирал	Баримт бичгийг олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын хавсралт, стандарт, зөвлөмжийн шаардлагад нийцүүлнэ.	Хагас байдлаар: 6 Жилийн байдлаар: 14	жилийн эцсийн	БХХ, ГХАХ ААДХДБА		
15.	2.1	"Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам"-д холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах.	Нэмэлт, өөрчлөлт оруулж, батлуулсан эсэх	I улирал	Нэмэлт, өөрчлөлт оруулах нэмэлт өөрчлөлтүүд: - Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын Нисэхийн аюулгүй байдлын аудитаас өгсөн зөвлөмж - TSA-ын шаардлага, зөвлөмж	Хагас байдлаар: I улиралд: "Иргэний аюулгүй журам"-д өөрчлөлт батлуулсан байна.	жилийн нисэхийн байдлын нэмэлт, орруулж,	Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын Нисэхийн аюулгүй байдлын аудитын дүгнэлтээр өгсөн зөвлөмжийн хүрээнд ИНАБЖ-д тусгах нэмэлт, өөрчлөлтийн саналыг боловсруулж, иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн гишүүн байгууллагуудаас 2024 оны 04 дүгээр сарын 16-ны 01/766 дугаар албан бичгээр санал авч нэгтгэн, Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, саналын товчоог Засгийн газрын тогтоолоор батлуулахаар 05 дугаар сарын 10-ны 02/1037 дугаар албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. Мөн уг нэмэлт, өөрчлөлтийн төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авахтай холбогдуулан нэмэлт материалыг боловсруулж, 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдөр цахимаар ЗТХЯ-нд хүргүүлсэн. Түүнчлэн журамд нэмж тусгах шаардлагын дагуу аудитын зөвлөмжийн холбогдох заалтуудын албан бус орчуулгыг 2024 оны 08	БХХ	90

							дугаар сарын 29-ний 01/1930 дугаартай албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн. Иргэний нисэхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхлэхтэй холбогдуулан энэхүү журмыг хуульд нийцүүлэн шинэчлэх шаардлага гарсан тул бүрэн шинэчилж, өмнө нь явуулсан нэмэлт, өөрчлөлтийн төслийг тусгаж 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 02/2671 дугаар албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн.		
16.	2.2	ИНД-13 “Албадлагын дүрэм”-ийг шинэчлэн батлуулах.	ИНД-13 батлагдсан эсэх	II-III улирал	ИНД-13 “Албадлагын дүрэм”-ийн шинэчилсэн найруулга 90 хувийн гүйцэтгэлтэй байна.	Хагас жилийн байдлаар: II улиралд: Дүрмийн төслийг боловсруулсан байна. Жилийн эцсийн байдлаар: III улиралд: ИНД-13 “Албадлагын дүрэм”-ийг шинэчлэн батлуулсан байна.	ИНД-13 “Иргэний нисэхийн дүрмийг албадан хэрэгжүүлэх үйл ажиллагаа” төслийг боловсруулж, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр www.mcaa.gov.mn цахим хуудаст байршуулан санал авч байна.	ААДХДБА	90
17.	2.3	Жишиг ИНД-ийн өөрчлөлтийн мониторинг хийж, шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг ИНД-д оруулж, батлуулах.	Батлагдсан дүрмийн тоо	II-III улирал	2019 онд 34 ИНД, 2021 онд 13 ИНД батлуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.	Хагас жилийн байдлаар: II улиралд: 4 ИНД Жилийн эцсийн байдлаар: III улиралд: 4 ИНД	Монгол Улсаас Америкийн Нэгдсэн Улс руу тогтмол агаарын тээврийн нислэг үйлдэх бэлтгэл ажлын хүрээнд Чикагогийн Конвенцийн 1, 6 ба 8 дугаар Хавсралт, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтүүдийн төслийг боловсруулсан. Мөн Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан нийт иргэний нисэхийн дүрмийг www.mcaa.gov.mn цахим хуудаст байршуулсан. Нийт 53 дүрэм болон “Эрх шилжүүлэх журам”-ыг /нийтдээ 54/ тус газрын цахим хуудаст байршуулсан. 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийг хүртэл эдгээр дүрэм, журмын	ААДХДБА	90

							хэлэлцүүлгийг зохион байгуулж, батлуулахаар Зам, тээврийн яаманд хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.		
18.	2.4	Эдийн засгийн зохицуулалтын баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулж, батлуулах.	Баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулж, батлуулсан эсэх	II-III улирал	Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2025 оноос хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан эдийн засгийн зохицуулалтыг хуультай нийцүүлэн шинэчлэн боловсруулж байна.	Хагас жилийн байдлаар: II улиралд: Дүрмүүдийг болон хавсралт бүрдүүлбэрийг боловсруулсан байна. Жилийн эцсийн байдлаар: III улиралд: 7 дүрмийг батлуулсан байна.	Дүрмүүдийг болон хавсралт бүрдүүлбэрийг боловсруулалтын ажлын хүрээнд олон улсын хуваарьт нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийг томилох, иргэний нисэхийн төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг тогтоох, зорчигч, тээш, ачаа тээвэрлэлтийн ерөнхий нөхцөл, иргэний нисэхийн статистикийн мэдээлэл цуглуулах, түгээх зэрэг дүрэм боловсруулах тухай хэлэлцүүлгийг 2024 оны 04 дүгээр сард зохион байгуулж, бүрдүүлбэрийг хийж гүйцэтгэсэн. 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр дахин санал авахаар ИНЕГ-ын цахим хуудсанд байршуулсан. Дүрмүүдэд холбогдох санал авч, мөн дахин хэлэлцүүлэг зохион байгуулахаар ажиллаж байна. Иргэний нисэхийн салбарын хөрөнгө оруулалтын зардал, үр ашгийн тооцоо хийх, мөн агаарын навигаци, нисэх буудал болон агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хөрөнгө оруулалт, аюулгүй байдлыг хангах санхүүгийн чадавхад үнэлгээ хийх тухай дүрмийг боловсруулж байна. 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр агаарын тээвэрлэгчид, нисэх буудал, агаарын навигацийн үйлчилгээний байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт оролцогчид дүрмийн төслүүдийг сайтар судлан 10 хоногийн хугацаанд санал ирүүлэхээр тогтсон. Захиргааны ерөнхий хуулийн дагуу холбогдох бүрдэл болох дүрмийн төслийн танилцуулга, нөлөөллийн	ГХАХ	70

							шинжилгээ, хэлэлцүүлгийн мэлээлэл, тэмдэглэлийг боловсруулж бэлдсэн. Саналыг ирүүлсний дараа нэгтгэн, үндэслэл бүхий саналыг тусган хүргүүлэхээр ажиллаж байна.		
19.	2.5	Агаарын тээвэрлэгчийг олон улсын нислэгийн шугамд томилох журмын төслийг боловсруулж, батлуулах.	Журам батлуулсан эсэх	I улирал	Журмын төсөл бэлэн болсон.	Хагас жилийн байдлаар: I улиралд: Журмын төслийг боловсруулан, хянуулж, Зам, тээврийн хөгжлийн сайдаар батлуулсан байна.	Агаарын тээвэрлэгчийг олон улсын нислэгийн шугамд томилох журмыг боловсруулж, 2024 оны 02 дугаар 14-ний өдөр Зам, тээврийн хөгжлийн яамны ИНБЗГ-ын мэргэжилтэнд, 22-ны өдөр мөн яамны Хуулийн хэлтсийн даргад цахимаар хүргүүлэн хянуулсан. Мөн дахин шинэчлэн 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдөр ЗТХЯ, ИНЕГ, агаарын тээвэрлэгчдийн төлөөллийг оролцуулан цахим хэлэлцүүлэг зохион байгуулж, "Агаарын тээвэрлэгчийг олон улсын нислэгийн шугамд томилох журам"-ыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/114 дугаар тушаалаар баталсан.	ГХАХ	100
20.	2.6	Хууль тогтоомж, бусад ИНД-үүдтэй зөрчилдөж, давхардал үүсгэдэг ИНД-үүдийг хүчингүй болгох.	ИНД-үүдийг хүчингүй болгосон эсэх	II-III улирал	Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2025 оноос хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан хууль тогтоомж, бусад ИНД-үүдтэй зөрчилдөж, давхардал үүсгэдэг ИНД-үүдийг хүчингүй болгох шаардлага үүссэн.	Хагас жилийн байдлаар: II улиралд: Санал, дүгнэлт гаргаж, холбогдох материалыг бэлтгэсэн байна. Жилийн эцсийн байдлаар: III улиралд: 12 ИНД-ийг хүчингүй болгосон байна. 1. ИНД-131 Агаарын хөлгийн түрээс; 2. ИНД-203 Агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах 3. ИНД-303 Агаарын тээвэрлэгчийн даатгал 4. ИНД-307 Захиалгат нислэгийн зөвшөөрөл	Монгол Улсын Ерөнхий сайдын "Шийдвэр хүчингүй болгох тухай" 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 192 дугаар захирамжаар ИНД-183, ИНД-138, ИНД-191, ИНД-203, ИНД-301, ИНД-303 хүчингүй болсон. ИНД-307, ИНД-313, ИНД-321, ИНД-329, ИНД-331 зэрэг дүрмүүдээс "ИНД" гэсэн тодотголыг авч, Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д нийцүүлэн "Иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээ олгох үйлчилгээний төрөл, хураамжийн хэмжээг тогтоох", "Статистикийн мэдээлэл", "Зорчигч, тээш, ачаа тээвэрлэлтийн ерөнхий нөхцөл", "Иргэний нисэхийн төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг тогтоох", "Олон улсын хуваарьт нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийг томилох", "Анкет	ААДХДБА	90

					<p>5. ИНД-313 Гадаадын агаарын тээвэрлэгчдийн үйлдэх захиалгат нислэг</p> <p>6. ИНД-321 Статистикийн мэдээлэл</p> <p>7. ИНД-329 Тээвэрлэлтийн гэрээ</p> <p>8. ИНД-331 Зорчигчдын бүртгэл</p> <p>9. ИНД-138 Эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа</p> <p>10. ИНД-144 Нисэхийн хангамжийн байгууллага, гэрчилгээжүүлэлт</p> <p>11. ИНД-183 Иргэний нисэхийн итгэмжлэгдсэн шалгагч</p> <p>12.ИНД-301 Ачааны агаарын тээвэрлэгчид эрх олгох.</p>	<p>шалгалт хийх”, “Агаарын хөлгийн түрээсийн журам”, “Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам” зэрэг дүрэм, журмын төслийг боловсруулж, www.mcaa.gov.mn цахим хуудаст байршуулсан.</p> <p>ИНД-131 “Агаарын хөлгийн түрээс”-ийг хүчингүй болгох хүсэлтээ холбогдох баримт бичгийн хамт 01/268 дугаартай албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн боловч Иргэний нисэхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан агаарын хөлгийн түрээстэй холбогдон гарах харилцааг энэхүү ИНД-131-ээр үргэлжлүүлэн зохицуулах нь зүйтэй гэж үзэж, Зам тээврийн хөгжлийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн "Иргэний нисэхийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай" А/71 дүгээр тушаалаар Зам тээвэр, хот байгуулалтын сайдын 2013 оны 160 дугаар тушаалын 16 дугаар тушаалаар батлагдсан ИНД-131 "Агаарын хөлгийн түрээс" дүрэмд нэмэлт, өөрчлөлт орсон.</p> <p>ИНЕГ-ын даргын зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хурлаар агаарын хөлгийн эд анги, бүтээгдэхүүн, сэлбэг хэрэгслийн хангамж логистик, шатахууны хангалтын үйлчилгээ үзүүлэгч байгууллагад зөвшөөрөл олгон гэрчилгээжүүлэх, үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавих, нисэхийн аюулгүй байдлыг дээшлүүлэх ач холбогдолтойг харгалзан ИНД-144 “Нисэхийн хангамжийн байгууллага, гэрчилгээжүүлэлт”-ийг цаашид мөрдөн ажиллах тухай 07/24-02 дугаар шийдвэр гарсан болно.</p> <p>ИНД-183 “Иргэний нисэхийн итгэмжлэгдсэн шалгагч дүрмийг ”Иргэний нисэхийн тухай хууль</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

							/шинэчилсэн найруулга/-ийн 11 дүгээр зүйл “Эрх шилжүүлэх”-ийн 11.3 дахь заалтыг үндэслэн “Эрх шилжүүлэх журам” болгон шинэчлэн боловсруулж, www.mcaa.gov.mn цахим хуудаст байршуулсан. ИНД-138 “Эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа” дүрмийн хувьд Чикагогийн Конвенцийн 12 дугаар Хавсралтад нийцүүлэн Иргэний нисэхийн дүрэм боловсруулагдсан байх тухай Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 9.2.1 дэх заалтыг үндэслэн хэвээр нь үлдээх нь зүйтэй гэж үзэж, мөн хуулийн 12.1.21 дэх заалтын дагуу уг дүрмийн төслийг www.mcaa.gov.mn цахим хуудаст байршуулсан.		
21.	2.7	Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны үндэсний төлөвлөгөөг боловсруулж, батлуулах.	Төлөвлөгөө батлагдсан эсэх	I-II улирал	Олон улсын иргэний нисэхийн байгууллагын DOC 10004 Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны 2020-2022 баримт бичгийн дагуу гишүүн орон бүр үндэсний төлөвлөгөөтэй байна.	Хагас жилийн байдлаар: I улиралд: Суурь судалгаа хийж, төслийг боловсруулсан байна. II улиралд: Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны үндэсний төлөвлөгөөг баталсан байна.	Монгол Улсаас Америкийн Нэгдсэн Улс руу тогтмол агаарын тээврийн нислэг үйлдэх бэлтгэл ажлын хүрээнд ИНЕГ-аас АНУ-ын Холбооны нисэхийн захиргаа /FAA/-ны аудит шалгалтад амжилттай хамрагдахад мэргэжлийн зааварчилгаа авах, бэлтгэл ажлыг хангуулахад зөвлөх үйлчилгээ болон техникийн туслалцаа авах зорилгоор ИНЕГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн баталсан “Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар”-ын дагуу тухайн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн боловсруулж ирүүлсэн “Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны үндэсний төлөвлөгөөний төсөл”-ийг Монгол хэл рүү хөрвүүлж, байгууллагын даргын тушаалаар батлуулахаар санал авч байна.	ААДХДБА	90
22.	2.8	Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрийг журам болгон	Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж	I-II улирал	Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны журмыг боловсруулж,	Хагас жилийн байдлаар: I улиралд: Суурь судалгаа хийж, төслийг боловсруулсан байна.	Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны журмын төслийг Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын жишиг загварын дагуу Англи хэл дээр (State Safety Programme Policy	ААДХДБА	90

		шинэчлэн боловсруулж батлуулах.	батлуулсан эсэх		батлуулах ажлын хэсгийг ИНЕГ-ын даргын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/116 дугаар тушаалаар байгуулсан.	II улиралд: Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрийг журам болгон шинэчлэн баталсан байна.	and Procedures Manual – Ed.No 1) боловсруулсан. Уг журмын төслийг Монгол хэл дээр хөрвүүлж, байгууллагын даргын тушаалаар батлуулахаар санал авч байна.		
Зорилт 3: АЯ ТУХТАЙ, ХЯМД ТИЙЗТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ НИСЛЭГИЙГ ЗОРЧИГЧДОД ХҮРГЭНЭ.			Зорчигч тээврийн хэмжээ (сая.хүн), Ачаа тээврийн хэмжээ (мянган тонн),	I-IV улирал	1.73 сая зорчигч 8.6 мянган тонн ачаа	2.2 сая зорчигч 12.0 мянган тонн ачаа	2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт 2,012,861 зорчигч тээвэрлэснээс олон улсад 1,625,255 зорчигч, орон нутагт 387,606 зорчигч, 9,205 тонн ачаа, 200 тонн шуудан тээвэрлэсэн. /Зорчигч тээвэр 91%-ийн гүйцэтгэлтэй, ачаа тээвэр 78%-ийн гүйцэтгэлтэй байна/	НААХЗА БХХ ГХАХ ЗУХЭЗХ СХОХ	
23.	3.1	Орон нутгийн хуваарьт нислэгийг тогтворжуулах.	Тогтворжуулсан хуваарьт нислэгийн чиглэлийн тоо	I-IV улирал	Орон нутагт 2023 онд тогтворжуулсан хуваарьт нислэгийн чиглэлийн тоо-8	Жилийн эцсийн байдлаар: I-IV улиралд: Дараах чиглэлүүдэд хуваарьт нислэг үйлдэж, орон нутгийн нислэгийг тогтворжуулсан байна. - Улаангом - Улиастай - Ховд - Мөрөн - Алтай - Өлгий - Чойбалсан - Даланзадгад - Баянхонгор	2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар “МИАТ” ТӨХК Улаангом, Улиастай, Ховд, Мөрөн, Алтай, Өлгий, Чойбалсан, Даланзадгад нийт 8 чиглэлд 63,812 зорчигч тээвэрлэсэн байна. “Хүннү Эйр” ХХК Ховд, Улаангом, Өлгий, Даланзадгад, Чойбалсан, Мөрөн нийт 6 чиглэлд 9,512 зорчигч тээвэрлэсэн байна. Хуваарьт нислэгийн зорчигч 28% өссөн үзүүлэлттэй байна. Уул уурхайн захиалгат нислэг буюу Оюутолгой чиглэлд нийт 314,249 зорчигч тээвэрлэсэн байна. Орон нутагт нийт 387,606 зорчигч тээвэрлэсэн ба энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.4% өссөн үзүүлэлттэй байна.	ГХАХ	100

24.	3.2	Монгол Улс, АНУ хооронд шууд нислэг эхлүүлэх.	АНУ-ын Холбооны нисэхийн захиргаа болон Тээврийн аюулгүй байдлын захиргааны аудит шалгалтад хамрагдсан эсэх Монгол Улс, АНУ хооронд шууд нислэг эхлүүлсэн эсэх	I-II улирал	2023 онд агаарын тээврийн тухай АНУ, Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулсан.	<p>Хагас жилийн байдлаар: I улиралд: АНУ-ын Холбооны нисэхийн захиргаа болон Тээврийн аюулгүй байдлын захиргааны аудит шалгалтын бэлтгэл ажлыг хангасан байна.</p> <p>II улиралд: АНУ-ын Холбооны нисэхийн захиргаа болон Тээврийн аюулгүй байдлын захиргааны аудит шалгалтад хамрагдсан байна. АНУ-руу шууд нислэг үйлдэх бэлтгэл ажлыг бүрэн хангасан байна.</p>	<p>Зам, тээврийн сайдын 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/171 дүгээр тушаалаар батлагдсан Монгол Улс-АНУ Засгийн газар хоорондын агаарын тээврийн харилцааг хөгжүүлэх, хоёр улсын хооронд шууд нислэг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэгч “Викс групп консалтинг” компанийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлын хэсэг, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/132 дугаар тушаалаар Дэд ажлыг хэсэг байгуулагдсан.</p> <p>1. “Викс групп консалтинг” компанийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлын хэсэг нь 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор АНУ-ын Холбооны нисэхийн захиргаанаас хийх Нисэхийн аюулгүй ажиллагааны аудит шалгалт, Тээврийн аюулгүй байдлын захиргааны урьдчилсан аудитад хамрагдах бэлтгэл ажлыг хангах чиглэлээр нийт 68 арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 18,5 хувьтай байна. Зөвлөх үйлчилгээг үзүүлсэн Америкийн Нэгдсэн Улсын “The Wicks Group Consulting” компаниас 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр ирүүлсэн гэрээний хэрэгжилтийн тайлан болон Залруулах арга хэмжээний төлөвлөгөөнд Монгол Улсын Иргэний нисэхийн хяналтын тогтолцоог Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт шаардлагад нийцүүлэх, илэрсэн үл тохирлыг залруулахад 18-24 сарын хугацаа шаардлагатай болох стратегийн зөвлөмж ирүүлсэн, 2025 оны 03 дугаар сард шууд нислэг үйлдэх боломжгүй талаарх албан бичгийг 2024</p>	НААХЗА БХХ ГХАХ ЗУХЭЗХ СХОХ	70
-----	-----	---	---	-------------	---	---	--	---	----

							<p>оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/2615 дугаартай албан бичгээр Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн.</p> <p>2. Дэд ажлын хэсэг нь ИНЕГ-ын даргын баталсан төлөвлөгөөний дагуу нийт 58 ажил төлөвлөгдсөнөөс тайлант хугацаанд буюу 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн дотор хийгдэх 47 арга хэмжээнээс</p> <p>100%-ийн биелэлттэй - 28; 90%-ийн биелэлттэй - 9; 70%-ийн биелэлттэй - 1; 50%-ийн биелэлттэй - 6; 30%-ийн хэрэгжилттэй - 3;</p> <p>Дүгнэх боломжгүй буюу хугацааг хойшлуулах шаардлагата - 4; Хугацаа болоогүй - 7 ажил байна. Нийт 86.5%-ийн биелэлттэй байна.</p> <p>Дэд ажлын хэсгийн тайланд тусгагдсан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх үүднээс Зам, тээврийн яамнаас тус ажлын хэсгийн ажиллах хугацааг 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд сунгахаар шийдвэрлэсэн. Ажлын явцыг 7 хоног бүр тайлагнан ажиллаж байна.</p> <p>Аудит шалгалтад 169,786,909.00 төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 150,646,328.00 төгрөгийг зарцуулсан. Мөн зөвлөх үйлчилгээний гэрээнд 1,439,635,590.00 төгрөгийг төсөвлөснөөс, 1,270,860,584.38 төгрөгийг санхүүжүүлсэн.</p>		
25.	3.3	Агаарын тээвэрлэгчдэд олон улсын томилгоо олгож, нислэгийн шугамыг хуваарилах.	Томилгооны тоо	I-IV улирал	Нийт 43 улстай АХХ-тэй, 122 (57) чиглэлд цэг сонгосон.	<p>Хагас жилийн байдлаар:</p> <p>I-II улиралд: 5 томилгоо</p> <p>Жилийн эцсийн байдлаар:</p> <p>III-IV улиралд: 5 томилгоо</p>	<p>2024 оны эхний томилгооны хурлыг 04 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулж, томилгооны хүсэлтийг судалж саналаа 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 02/732, 02/733 дугаартай албан бичгүүдээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>ЗТХС-ын 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/116 дугаар тушаалаар</p>	ГХАХ	100

						<p>“Хүннү Эйр” ХХК-д Ордос чиглэлд зорчигч тээврийн хуваарьт нислэг гүйцэтгэх томилгоо олгосон.</p> <p>2024 оны 2 дугаар улирлын томилгооны хурлыг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж, томилгооны хүсэлтийг судалж саналаа 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 01/1301 дугаартай албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. ЗТХС-ын 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/151 дугаар тушаалаар БНХАУ-ын 9 чиглэлд “МИАТ” ТӨХК-ийг маркетингийн агаарын тээвэрлэгчээр томилсон.</p> <p>ЗТС-ын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/155, А/156 дугаартай тушаалуудаар “Изинис Эйрвэйз” ХХК-ийг Эрхүү, Новосибирск, Владивосток, Хо Ши Мин, Ханой чиглэлд хуваарьт нислэг гүйцэтгэх томилгоо олгосон.</p> <p>2024 оны 3 дугаар улирлын томилгооны хурлыг 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулж, томилгооны хүсэлтүүдийг хэлэлцүүлэн, 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 01/1939 дугаартай албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн.</p> <p>ЗТС-ын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/188 дугаар тушаалаар “МИАТ” ТӨХК-ийг Ташкент чиглэлд ачаа тээврийн хуваарьт нислэг гүйцэтгэгчээр, 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/189 дүгээр тушаалаар “Хүннү Эйр” ХХК-ийг Ташкент, А/192 дугаар тушаалаар “Аэромонголиа” ХХК-ийг Москва, А/190, А/191 дүгээр тушаалуудаар “Изинис Эйрвэйз” ХХК-ийг Самарканд, Шеньжэнь чиглэлд тус тус зорчигч тээврийн хуваарьт нислэг гүйцэтгэгчээр томилгоо олгосон.</p> <p>2024 онд ачаа тээврийн 1, аяллын дугаар хамтран ашиглах 9, зорчигч</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

							тээврийн 10, нийт 20 томилгоо олгоод байна.		
26.	3.4	Олон улсын шинэ чиглэлд шууд нислэг эхлүүлэх.	Олон улсын шинэ чиглэлд шууд нислэг эхлүүлсэн эсэх	I-IV улирал	Агаарын тээврийн тухай БНХАУ, БНСВьетнам Улс, ОХУ-тай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулсан.	<p>Хагас жилийн байдлаар: I-II улиралд: Шууд нислэг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд эрх зүйн зохицуулалтад зохих нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.</p> <p>Жилийн эцсийн байдлаар: III-IV улиралд: Дараах чиглэлүүдэд шууд нислэг эхлүүлсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> - БНХАУ (Эрээн-Мөрөн) - БНСВУ (Хошимин) - ОХУ (Новосибирск) 	<p>Дотоодын агаарын тээвэрлэгчид шинээр нислэг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд шинээр нислэг эхлүүлэх улсын иргэний нисэхийн удирдах байгууллагаас гадаадын агаарын тээвэрлэгчээр гэрчилгээжих, тухайн нисэх буудлаас нислэгийн цагийн хуваарийн зөвшөөрөл авах, газрын үйлчилгээний гэрээ байгуулах, төлөөлөгчийн газар байгуулах ажлууд хийгдсэн. Үүнд:</p> <p>“Хүннү Эйр” ХХК БНХАУ-ын Эрээн чиглэлд долоо хоногт 7 удаагийн, Саньяа, Хайкоу чиглэлд долоо хоногт 1 удаагийн хуваарьт нислэг гүйцэтгэж эхлээд байна.</p> <p>“Изинис Эйрвэйз” ХХК Чех Улсын Прага чиглэлд нислэг үйлдэх бэлтгэл ажлыг хангуулж, агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний хавсралт үйл ажиллагааны тодорхойлолтод өөрчлөлт оруулсан. 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн долоо хоногт 2 удаагийн давтамжтай хуваарьт нислэг үйлдэж эхэлсэн.</p> <p>“Хүннү Эйр” ХХК БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ордос хотын чиглэлд нислэг гүйцэтгэх бэлтгэл ажлыг ханган 2024 оны 08 дугаар сарын 17-ны өдөр анхны нислэгээ эхлэн, долоо хоногт 2 удаагийн давтамжтай хуваарьт нислэг үйлдэж эхэлсэн.</p> <p>ОХУ-ын ИрАеро компани Эрхүү чиглэлд долоо хоногт 3 удаагийн давтамжтай, Красавиа компани Красноярск хотын чиглэлд долоо хоногт 2 удаагийн давтамжтай хуваарьт нислэг үйлдэж байна.</p> <p>БНСВУ-ын Хо Ши Мин чиглэлд МИАТ ТӨХК 2024 оны өвлийн нислэгийн</p>	ГХАХ	90

							хуваарьт батлуулан долоо хоногт 2 удаагийн давтамжтай нислэг үйлдэнэ.		
27.	3.5	Хуваарьт нислэг гүйцэтгэж байгаа дотоодын агаарын тээвэрлэгчдийг дэмжих зээл олголтыг үргэлжлүүлэх.	Зээлийн хөрөнгө оруулалтын үр ашгийн тооцооллыг хянасан эсэх	I-IV улирал	Зээл олголт эхэлсэн.	Хагас жилийн байдлаар: I-II улиралд: Зээл олголттой холбогдуулан Засгийн газрын зээлийн хөрөнгө оруулалтын үр ашгийн тооцооллыг тухай бүрд хянаж, Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн байна. Жилийн эцсийн байдлаар: III-IV улиралд: Зээл олголттой холбогдуулан Засгийн газрын зээлийн хөрөнгө оруулалтын үр ашгийн тооцооллыг тухай бүрд хянаж, Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн байна.	Тайлант хугацаанд хуваарьт нислэг гүйцэтгэж байгаа дотоодын агаарын тээвэрлэгчдээс хөнгөлөлттэй зээл авах талаар хүсэлт, зарцуулалт, буцаан төлөх талаарх тооцоолол ирүүлээгүй байна.	ГХАХ	100
28.	3.6	Дотоодын агаарын тээвэрлэгчдийн нислэг, санхүүгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.	Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар ирүүлсэн хүсэлтийг тухай бүр судалж, саналыг Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн эсэх	I-IV улирал	Төлөвлөлтийн шатанд.	Хагас жилийн байдлаар: I-II дугаар улиралд: Дотоодын агаарын тээвэрлэгчдээс нислэг, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар ирүүлсэн хүсэлтийг тухай бүр судалж, саналыг Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн байна. Жилийн эцсийн байдлаар: III-IV дүгээр улиралд: Дотоодын агаарын тээвэрлэгчдээс нислэг, санхүүгийн үйл	ЗТХЯ-ны 2024 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн 03/1148 дугаартай албан бичгээр ирүүлсэн дунд оврын агаарын хөлгийн судалгаа хийх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломжийн талаарх тооцоолол ирүүлэх хүсэлтийн дагуу холбогдох судалгаа, тооцоог хийж, санал дүгнэлтийг ЗТХЯ болон Монголын агаарын тээвэрлэгчдийн холбоонд 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 01/603 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн.	ГХАХ	100

						ажиллагаатай холбоотой асуудлаар ирүүлсэн хүсэлтийг тухай бүр судалж, саналыг Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн байна.			
29.	3.7	Олон улсын хэмжээнд Монгол Улсыг сурталчлах, жуулчин татах арга хэмжээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллах.	Арга хэмжээнд дэмжлэг үзүүлсэн эсэх	I-II улирал	2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан олон улсад Монгол улсыг суртчилах, жуулчдыг татах арга хэмжээг агаарын тээвэрлэгч байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	Хагас жилийн байдлаар: I-II улиралд: Монгол Улсын аялал жуулчлалыг дэмжих, сурталчлан таниулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлж оролцсон байна.	Олон улсын хэмжээнд Монгол Улсыг сурталчлах, жуулчин татах арга хэмжээний талаар судалж, бэлтгэл ажил ханган 2024 оны 02 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд Малайз Улсын Лангкави хотод зохион байгуулагдсан Ази Номхон далайн бүс нутгийн агаарын тээврийн шинэ чиглэл, урсгалыг хөгжүүлэх зорилготой ROUTES ASIA-2024 арга хэмжээнд "Чингис хаан" олон улсын нисэх буудлаас төлөөлөгчид оролцсон бөгөөд тус арга хэмжээнд Монгол Улсын агаарын тээврийн өнөөгийн байдал, зорчигч нэвтрүүлэх боломж, бусад улс оронтой байгуулсан Агаарын харилцааны хэлэлцээрийн талаарх мэдээлэл зэргийг бэлтгэн өгч хамтран ажилласан. Тус арга хэмжээнд Ази Номхон далайн бүс нутгийн 600 гаруй агаарын тээвэрлэгчид, нисэх буудлууд, аялал жуулчлалын компаниуд оролцсон. "GO MonGolia" нэгдсэн брэндиг дор Монгол Улсыг олон улсад сурталчлах арга хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-д амжилттай зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээнд Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ, БОАЖЯ, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, "Хүннү Эйр" компанийн удирдлага болон БНХАУ-ын Аялал жуулчлал хариуцсан Засгийн газрын төлөөлөл, аялал жуулчлалын байгууллагууд	ГХАХ	100

							болон нисэх буудлуудын төлөөлөл оролцож харилцан аялах боломжуудын талаар санал солилцлоо.		
30.	3.8	Тогтвортой агаарын хөлгийн шатахуун /SAF-Sustainable Aviation Fuels/-ны талаар судалгаа хийж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлэн, шийдвэр гаргуулах.	Судалгаа хийж, шийдвэр гаргуулсан эсэх	II улирал	Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын тогтвортой агаарын хөлгийн шатахуун /SAF-Sustainable Aviation Fuels/ бодлогыг Монгол Улсад хэрэгжүүлэх, дэлхийн чиг хандлагыг харуулсан судалгааны ажил хийгдэж байгаагүй.	Хагас жилийн байдлаар: II улиралд: Судалгаа хийж, Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлж, шийдвэр гаргуулсан байна.	Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын тогтвортой агаарын хөлгийн шатахуун /SAF-Sustainable Aviation Fuels/ бодлого, дэлхийн чиг хандлага, Монгол Улсад хэрэгжүүлэх боломжийн талаарх судалгааны ажлыг хийж, 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 01/1160 дугаартай албан бичиг ЗТХЯ-нд хүргүүлсэн.	ГХАХ	100
31.	3.9	Транзит зорчигчийн урсгалыг нэмэгдүүлэх.	Транзит зорчигчийн тоо	I-IV улирал	2023 онд 15.8 мянган транзит зорчигч зорчсон байна.	Хагас жилийн байдлаар: I-II улиралд: Транзит зорчигчийн тоог 5 хувь нэмэгдүүлсэн байна. Жилийн эцсийн байдлаар: III-IV улиралд: Транзит зорчигчийн тоог 10 хувь нэмэгдүүлсэн байна.	2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 15.523 транзит зорчигч зорчсон бол 2023 оны мөн үед 13,143 транзит зорчигч зорчсон нь транзит зорчигчийн тоо 18% нэмэгдсэн үзүүлэлттэй байна. “МИАТ” ТӨХК-аас Агаарын тээврийн компаниудын өнөөгийн байдалтай уялдуулан транзит зах зээлийн боломжийг тодорхойлж, 6-р эрхийн зорчигч тээвэр хөгжүүлэхэд хэрэгжүүлэх бодлого, эрх зүйн асуудлуудыг хэлэлцэхээр “Transit Mongolia” арга хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт ЗТХЯ, БОАЖЯ, ИНЕГ, Гадаадын иргэн, харьяатын газар, агаарын тээвэрлэгчид, хил, гааль, зочид буудал, аялал жуулчлалын холбоодын төлөөлөл оролцсон.	БХХ ГХАХ	100

32.	3.10	Агаарын тээврийн зорчигчдод тийзийн төлбөрийг хэсэгчилсэн төлөх зохицуулалтыг банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран бүрдүүлэх.	Төлбөр хэсэгчилж төлөх зохицуулалт бүрдсэн эсэх	I-III улирал	“МИАТ” ТӨХК тийзийн төлбөрийг санхүүгийн байгууллагатай хамтран 4 хувааж төлөх нөхцөлийг анхлан нэвтрүүлээд байна.	Хагас жилийн байдлаар: I улиралд: Банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран тийзийн үнийг хэсэгчилсэн төлөх зохицуулалт бүрдүүлсэн байна. II-III улиралд: Дотоодын агаарын тээвэрлэгчдийг уг зохицуулалтад хамруулсан байна.	Хуваарьт нислэг гүйцэтгэж буй дотоодын агаарын тээвэрлэгчид болох “МИАТ” ТӨХК, “Хүннү Эйр” ХХК, “Изинис Эйрвэйз” ХХК, “Аэромонголиа” ХХК-ууд Сторпэй /storepay/ санхүүгийн байгууллагатай гэрээ байгуулан тийзийн үнийг 4 хуваан төлөх боломжтойгоор үйлчилгээ үзүүлж байна.	ГХАХ СХОХ	100
